



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 538

Улаанбаатар хот

Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийн мерөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 400 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих журам”-ын 3.6, 4.1, 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний 2020 оны биелэлтийн дүнгээр “Сайн” дүгнэгдсэн хавсралтад заасан төрийн өмчит хуулийн этгээд (эсхүл ажилтан)-ийг холбогдох журамд заасны дагуу шагнаж, урамшуулахыг зөвшөөрсүгэй.

2.Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийн дүнгээр дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл), Захиргаа, удирдлагын хэлтэс (Н.Ганболд)-т тус тус даалгасугай:

2.1.Гэрээний биелэлтийн дүнгээр газар эзэмших, ашиглах эрхийн баталгаажилт, үнэлгээ, шилжилт хөдөлгөөн, үл хөдлөх болон хөдлөх үндсэн хөрөнгийн бүртгэл, ашиглалтад илэрч буй зөрчил дутагдлыг арилгах талаар зөвлөмж боловсруулж төрийн өмчит хуулийн этгээдэд хүргүүлэх;

2.2.Автотээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээлэл, үл хөдлөх хөрөнгийн ашиглалт, түрээстэй холбоотой судалгаа мэдээллийг шинэчлэх, зөрчил дутагдлыг арилгах ажлыг 2022 онд явагдах төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын ажлын төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх;

2.3.Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлжүүлэх систем”-ийг шинэчлэх төсөл, бодлогын даалгавар боловсруулан, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

3.Төрийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал нарт дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

3.1.Хөрөнгийн ашиглалттай холбоотой гарсан тогтоолыг мөрдөж ажиллах, цаг хугацаанд нь хэрэгжүүлж биелэлтийг гарган ирүүлж байх;

3.2.Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад тавих хяналтыг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;

3.3.Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн доорх газрын эзэмших, ашиглах эрхийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу баталгаажуулах, үнэлэх, бүртгэлд тусгах, Засгийн газрын 2013 оны 38 дугаар тогтоолын 6 дугаар заалт, 2020 оны 10 дугаар тогтоолыг тус тус хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;

132006913

3.4.Авто тээврийн үндэсний төвийн тээврийн хэрэгслийн улсын бүртгэл болон татвар төлөгчдийн бүртгэлд байгаа өөрийн байгууллагын тээврийн хэрэгслийн мэдээ, мэдээллийг тулган баталгаажуулж, 2022 оны 1 дүгээр улиралд багтаан илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авах, өөрчлөлт, хөдөлгөөнийг тухай бүр тусгуулж байх;

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2021 оны 12 дугаар сарын 02-ны
өдрийн 38 дугаар тогтоолын хавсралт

Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийн дүнгээр "Сайн"
авсан төрийн өмчит хуулийн этгээд болон ажилтаны нэрс

№	Төрийн өмчит хуулийн этгээд /ажилтны/ ийн нэр
1	Хэнтий аймаг Бор-Өндөр сум дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
2	АШУҮИС-ийн Говь-Алтай аймаг дахь салбар Анагаах ухааны сургууль
3	Ховд их сургууль
4	Монгол-Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургууль
5	Үндэсний статистикийн хороо
6	АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах ухааны сургууль
7	Уран зургийн галлерей
8	"Шингэн түлш ачих байгууламж" ТӨҮГ
9	ОБЕГ-ын дэргэдэх 185 дугаар анги
10	Стандарт хэмжил зүйн газар
11	Өвөрхангай аймгийн Онцгой байдлын газар
12	Завхан аймгийн Онцгой байдлын газар
13	Багануур дүүрэг дэх Хилийн 0252 дугаар анги
14	Шинжлэх ухаан технологийн их сургууль
15	Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн алба
16	Цагдаагийн ерөнхий газрын Автобааз
17	Гааль Татварын мэдээлэл технологийн үндэсний төв УТҮГ
18	Багануур дүүрэг дэх 427-р хаалттай хорих анги
19	Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь ШШГХ-ийн 423-р хорих анги
20	Дотоод хэргийн их сургууль
21	Харилцаа холбооны зохицуулах хороо
22	Улсын бүртгэлийн ерөнхий газар
23	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК
24	Улаанбаатар хот дахь Гаалийн газар
25	Увс аймгийн Автотээврийн төв
26	Төв аймгийн Автотээврийн төв
27	Сэлэнгэ аймгийн Татварын хэлтэс
28	Төрийн банкны Дорнод аймгийн салбар
29	Увс аймгийн Дэглий цагаан Нисэх буудал
30	"Налайх-АЗЗА" ТӨХК
31	"Баянчандмань-АЗЗА" ТӨХК
32	"Улаанбаатар Дулааны Сүлжээ" ТӨХК
33	"Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн" ТӨҮГ
34	Дорнод аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
35	Монгол Улсын их сургууль

	Төрийн өмчит хуулийн этгээдийн ажилтны нэр
36	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын нягтлан бодогч Б.Наранцацрал
37	Эрүүл мэндийн хөгжлийн төвийн нягтлан бодогч П.Саранцэцэг
38	Улсын Их Хурлын Тамгын газрын нягтлан бодогч Э.Энхтунгалаг
39	Хавдар судлалын үндэсний төвийн нягтлан бодогч Ц.Энхээ
40	Дорноговь аймаг дахь МСҮТ-ийн нягтлан бодогч У.Дэлгэрбуян
41	Говь-Алтай аймаг дахь ХХҮГазрын нягтлан бодогч Л.Удвал
42	Ховд аймаг дахь БЭОТ-ийн нягтлан бодогч Ц.Олонбаяр
43	Математик тоон технологийн хүрээлэн нягтлан бодогч М.Буяннэмэх
44	Олон улс судлалын хүрээлэнгийн нягтлан бодогч Б.Ганчимэг
45	Монгол улсын консерваторын нягтлан бодогч Д.Батдэлгэр
46	Уул уурхайн хүнд үйлдвэрийн яамны нягтлан бодогч Б.Ганчимэг
47	Насан туршийн боловсролын үндэсний төвийн нягтлан бодогч Ш.Сарангэрэл
48	Их сургуулиудын хотхоны АӨЗ-ны нягтлан бодогч Р.Даваажаргал
49	Улсын драмын театрын нягтлан бодогч Б.Ариунзул
50	"Монголросцветмет" ТӨҮГ-ын нягтлан бодогч Б.Мөнхбаяр
51	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын нягтлан бодогч О.Алтансарнай
52	Өвөрхангай аймгийн СХЗХ-ийн нягтлан бодогч В.Отгонцэцэг
53	Хөвсгөлийн УТХЗахиргааны нягтлан бодогч Ш.Туяа
54	Улсын филармонийн нягтлан бодогч Б.Сонинцэцэг
55	Буйр нуур-Мэнэнгийн талын СГЗахиргааны нягтлан бодогч Г.Гантуяа
56	Зам, тээврийн хөгжлийн яамны нягтлан бодогч Г.Алтангэрэл
57	Баян-Өлгий аймаг дахь Гаалийн газрын нягтлан бодогч С.Алтанзул
58	Баян-Өлгий аймгийн Автотээврийн төвийн нягтлан бодогч Ж.Айболат
59	Татварын ерөнхий газрын нягтлан бодогч Н.Долгорсүрэн
60	Төрийн банкны Увс аймгийн салбарын нягтлан бодогч Я.Чимгээ
61	ИНЕГ-ын Авто баазын нягтлан бодогч С.Тамир
62	Харгуй ТӨХК-ийн нягтлан бодогч Одончимэг
63	Газарзүй геоэкологийн хүрээлэнгийн нягтлан бодогч Б.Лхагвасүрэн
64	Монгол тэмүүлэл сургуулийн нягтлан бодогч Х.Орхончимэг
65	"Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ-ын нягтлан бодогч Г.Гантуул
66	Дарханы Дулааны цахилгаан станц ТӨХК-ийн нягтлан бодогч Ц.Ууганбаяр
67	"Улаангомын дулааны 2 дугаар станц" ТӨХК-ийн нягтлан бодогч Н.Сарнай
68	Ховд аймгийн ГХБХБГ-ын нягтлан бодогч Г.Эсбаатар
69	УБТЗ ХНН-ийн үндсэн хөрөнгийн нягтлан бодогч
70	БМДИнститутийн нягтлан бодогч Ц.Чандмань
71	ШШГЕГ-ын Санхүү, аж ахуйн хэлтсийн мэргэжилтэн Ц.Гантуяа
72	ШУТИС-ын нягтлан бодогч Н.Баярмаа